



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар А/208

Булган сум

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны XII/90 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих “Аймгийн 8 сумын геодезийн цэг тэмдэгтийн тооллого явуулах (Баян-Агт, Бугат, Булган, Сайхан, Сэлэнгэ, Тэшиг, Хангал, Хутаг-Өндөр)” ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2026 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн хурлын зөвлөмжийн дагуу гүйцэтгэгчээр шалгарсан “Гранд-Амур” ХХК-тай 77,900,000 (далан долоон сая есөн зуун мянга) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2. Гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т үүрэг болгосугай.

3. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандарт, ажлын даалгаврын дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг “Гранд-Амур” ХХК-ийн захирал (Ц.Ууганбаяр)-д даалгасугай.

4. Гэрээнд тусгах нөхцөл шаардлагыг 1 дүгээр хавсралтаар, тухайн төсөл арга хэмжээг гүйцэтгэхээр санал болгосон инженер, техникийн ажилчид, машин механизмын жагсаалтыг 2 дугаар хавсралтаар тус тус баталж, заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусган хяналт тавин ажиллахыг хариуцсан албан тушаалтнуудад даалгасугай.

5. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг тус сангийн нягтлан бодогч (Б.Очирсүрэн)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА


Д.ПҮРЭВ-ОЧИР



6326010278

Сүлжээ Ажил 2026 өдөр бүр Doc/2026/Захирамж

Аймгийн Засаг даргын 2026 оны
03 дугаар сарын 25-ний өдрийн
А/208 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт



Гэрээнд тусгах нөхцөл шаардлага

д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.3 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна.	Б.Ариунболд
2	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5-10 хувийн хооронд сонгоно.	Б.Ариунболд Ү.Бямбасүрэн
3	Ажил гүйцэтгэх хугацаа	Хуанлийн 90 хоног	Ү.Бямбасүрэн

--o00o--

Аймгийн Засаг даргын 2026 оны
03 дугаар сарын 25-ны/ний өдрийн
А/208 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт

Тухайн төсөл арга хэмжээг гүйцэтгэхээр санал болгосон инженер, техникийн
ажилчид, машин механизмын жагсаалт

Инженер, техникийн ажилчид			Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
д/д	Албан тушаал	Ажилтны нэр	
1	Геодезийн инженер	Ц.Ууганбаяр	Ү.Бямбасүрэн
2	Техникч	Ч.Амармэнд	
Машин механизмын жагсаалт			Ү.Бямбасүрэн
д/д	Машин механизмын нэр	Улсын дугаар	
1	Туулах чадвар сайтай автомашин	1149 УНУ	

--o00o--